# ХЭНТИЙ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# 05 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 04 сарын 11 өдөр Дугаар 06 Чингис хот

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах,
дасан зохицох үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт" батлах тухай 407 дугаар тогтоол, Уур амьсгалын Үндэсний хорооны 2024 оны “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө” батлах тухай 01 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тавдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хэнтий аймгийн “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2030 он)”- г хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусгах, хувийн хэвшил, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, хандив тусламжийг татах, шаардлагатай удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж, тайланг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Аюурбунь)-д даалгасугай.

3.“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөө (2025-2030 он)”-г өөрийн суманд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо (Г.Тайванжаргал)-нд үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦОГТ-ОРШИХ

*Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 11 өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт*

# ХЭНТИЙ АЙМГИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ, ДАСАН ЗОХИЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

**(2025-2030 он)**

Үндэслэл

Хэнтий аймаг нь хөдөө аж ахуй голлосон, газар тариалан хөгжсөн, уул уурхай идэвхитэй хөгжиж байгаа, нийт газар нутгийн 46.4 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдэг, нуур, гол мөрөн зэрэг гадаргын усны эх үүсвэр ихтэй, малын тоо толгой 3.1 сая толгой ба улсад малын тоогоор эхний 5 аймагт багтдаг, бэлчээрийн даац хэтэрсэн, газрын доройтол, цөлжилт нүүрлэсэн, хүн амын амьжиргааны түвшнээр улсад дөрөвдүгээрт ордог аймаг юм. Иймд аймгийн хэмжээнд байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, болон дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх нэгдсэн бодлоготой болох хэрэгцээ шаардлага буйг үндэслэн 2025-2030 онуудад байгаль орчныг хамгаалах, нөөцийг хамгаалах, үр ашигтай хэрэглээг дэмжих, газрын доройтол, цөлжилт, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр доорх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эрхэм зорилго

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой салбарын хууль тогтоомж, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогууд, салбарын бусад бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн эдийн засгийн голлох салбаруудын хүлэмжийн хийн ялгарал болон уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, “Монгол орны уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө-2030”–ийн хэрэгжилтийг хангахад оршино.

Үр дүн

1. Хэнтий аймгийн тогтвортой хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, дасан зохицох бодлого төлөвлөлтийг сайжруулан, орчны бохирдлыг бууруулах, төсөв хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрүүл, оюунлаг иргэнтэй, цэвэр аюулгүй орчинтой, байгальд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээг дэмжсэн, тогтвортой засаглалтай ногоон аймаг болно.
2. Төв суурин газарт сайжруулсан ариун цэврийн байгууламж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд нийцсэн нийгмийн үйлчилгээ, нүүрстөрөгчийн ялгарал багатай, нөөцийн хэмнэлттэй технологийн шийдлийг нэвтрүүлж, иргэдийн оролцоотойгоор хүлэмжийн хийн ялгарал, агаар, хөрс, усны бохирдлыг бууруулна. Ингэхдээ аж ахуйн нэгж, албан байгууллагууд болон нийтийн орон сууц, гэр, байшинд амьдардаг айл өрхийн эрчим хүчний хэмнэлтийг сайжруулж, хүрэн эрчим хүчний хэрэглээг үе шаттайгаар бууруулсан байна.
3. Орон нутгийн иргэдэд байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон дадал, зан үйлийг хэвшүүлж, орчны бохирдлыг бууруулан, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

# ХЭНТИЙ АЙМГИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ, ДАСАН ЗОХИЦОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

**(2025-2030 он)**

| № | Бодлогын үндэслэл | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн үзүүлэлт буюу хүрэх түвшин | | | | Санхүүгийн эх үүсвэр, хувиар | | | | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин 2024 он | 2025-2026 он | 2027-2028 он | 2029-2030 он | УТ | ОНТ | ТХ | ОТ | |
| | ***Чадавхи бэхжүүлэх стратеги чиглэл: Иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа, түншлэл*** | | | | | | | | | | | |
| | ***Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох санхүүгийн хөшүүрэг, механизмийн эрх зүйн орчинг бүрдүүлэх.*** | | | | | | | | | | | |
| *1.1* | *АЗДҮАХ 3.3.3.1* | Аймгийн тогтвортой хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, сааруулах, дасан зохицох төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах | Ажлын хэсэг | 1 | 1 | | | | | | | Аймгийн ИТХ, ЗДТГ |
| *1.2* | *УАӨДЗҮТ 1.1* | Аймгийн хэмжээнд эрчим хүч, ХАА, аж үйлдвэр, хог хаягдлын салбаруудаас болон ААН байгууллага, айл өрхийн хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) тооцоог гаргаж, тооллого хийх, дүн мэдээг орчны бохирдлын мэдээллийн програмд тусгаж үе шаттай бууруулах, дүйцүүлэх төлөвлөгөө гаргах | Аймгийн ХХЯ тооллогын тайлан | 0 | 1 | | 1 | 50 | 50 | | | Ажлын хэсэг |
| *1.3* | | Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж 2 жилийн давтамжит ХХЯ тооллогыг хийлгэдэг болох | ХХЯ тооцоо | 0 | 1 | 1 | 1 | 50 | 50 | | | Аймаг, сумын ЗДТГ, БОГ |
| *1.4* | *АХ 6.2.1 МУХТЖҮЧ 6.2.2 УАӨДЗҮТ 3.3* | Байгалийн ургамал, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн нөөцийг өсгөн үржүүлэх, хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлыг шат дараатай нэмэгдүүлэх | амьтанд зарцуулсан зардал, хувь | 50 | 50 | 50 | 50 | | | | 100 | Аймаг, сумын ИТХ, БОГ |
| | | | ургамалд зарцуулсан зардал, хувь | 15 | 15 | 15 | 15 | | | | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | АХ 6.2.4 МУХТЖҮЧ 6.4.2 УАӨДЗҮТ 1.5 | Тариалангийн талбайгаа хашиж хамгаалж, ойжуулж байгаа аж ахуйн нэгжийг урамшуулах, урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамруулах | хамрагдсан тоо | 0 | 1 | 2 | 3 | | | | 100 | Аймаг, сумын ИТХ, ХХААГ |
| 1.6 | АХ 8.3 МУХТЖҮЧ 8.3.5 | Бэлчээр ашиглалтын төлбөр авах эрх зүйн орчинг бүрдүүлж, нийт малчдын 10%-ийг хамруулах, дундын сан байгуулах | малчин өрхийн тоо | нийт малчин өрх 9178 | 500 өрх | 700 өрх | 900 өрх | | 20 | | 80 | Аймаг, сумын ИТХ, ХХААГ |
| 1.7 | | Дундын сангийн зарцуулалтыг бэлчээрийг нөхөн сэргээх, малын тоо, сүргийн бүтцийг бэлчээрийн даацад нийцүүлсэн сайн малчинд олгох урамшууллалд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх | урамшуулал олгосон малчны тоо, хувь | нийт малчин өрх 9178 | малчдын 3% -ийг хамруулах | малчдын 8% -ийг хамруулах | малчдын 12% -ийг хамруулах | | 20 | | 80 | ХХААГ, Сумдын ЗДТГ, малчид |
| 1.8 | МУХТЖҮЧ 6.2.4 | Уул уурхайн бизнес эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй байгуулах гэрээнд дүйцүүлэн хамгаалах аргаар хөв цөөрөм байгуулах, бэлчээрийг нөхөн сэргээх, ойжуулах асуудлыг тодорхой тусгаж хэрэгжүүлэх | Хөв цөөрөм байгуулсан тоогоор | 13 хөв цөөрөм байгуулсан | 1 | 1 | 1 | | | | 100 | Аймаг, сумын ЗДТГ, БОГ |
| 1.9 | АЗДҮАХ 3.3.2.1 | Ойг нөхөн сэргээхэд олон нийтийн санаачилга, оролцоог нэмэгдүүлэх, манлайлж ажиллаж буй аж ахуйн нэгжийг урамшуулах, сурталчилах | үйл ажиллагааны тоо | жилд 5 | 5 | 10 | 15 | | 20 | | 80 | Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, БОГ |
| 1.10 | АХ 6.4.12 7.3.22, 8.3.2 МУХТЖҮЧ 6.4.2 УАӨДЗҮТ 1.10 | Хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийн менежментийн системийг сайжруулж, даатгалын тогтолцооны цар хүрээг нэмэгдүүлэх | Даатгалд хамрагдсан малчдын тоо, хувиар | нийт малчин өрх 9178 | 5% | 10% | 15% | | | | 100 | ХХААГ, Даатгалын компани, малчид, тариаланчид |
| | | | Даатгалд хамрагдсан тариаланчдын тоо, хувиар | Нийт тариалангийн ААН тоо | 5% | 10% | 15% | | | | 100 | |
| 1.11 | АХ 8.3.3-4 6.2.12 МУХТЖҮЧ 8.3 УАӨДЗҮТ 10.1 | Бэлчээрийг эзэнтэй болгох, хил заагийг тогтоож, урт хугацаагаар эзэмших гэрээ байгуулах, хариуцлагажуулах, сум бүр бэлчээрийн журамтай болох | сумын тоо | 1 | 5 сум | 10 сум | 18 сум | | 100 | | | ХХААГ, Сумын ЗДТГ, ИТХ, малчид |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *1.12* | | Нийт бэлчээрийн 10%-ийг отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгон хамгаалалтад авч цаг хүндэрсэн үед ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлэх | нөөц бэлчээрийн эзлэх хувь, га | 0 | 5% | 10% | 15% | 50 | 50 | | | ХХААГ, Сумын ЗДТГ, ИТХ, малчид |
| *1.13* | *АХ 6.1.4 МУХТЖҮЧ 6.1.1* | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах | Хэрэгжүүлсэн арга хэмжээний Тоо | 2024 онд 14 арга хэмжээ | Жилд 2 арга хэмжээ | Жилд 2 арга хэмжээ | Жилд 2 арга хэмжээ | | 20 | 30 | 50 | БОГ, СЗДТГ, ТХГЗ |
| *1.14* | *АХ 8.3.18-19, 21 МУХТЖҮЧ 8.3.5 УАӨДЗҮТ 11.3* | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шинэ болон дахин сэргэж буй, мал, амьтны халдварт өвчний шалтгааныг судлан тогтоох, хариу арга хэмжээний стратеги боловсруулан хэрэгжүүлэх | стратеги хэрэгжилтийн хувь | 0 | 30 | 60 | 100 | 40 | | 30 | 30 | МЭГ, Сумын ЗДТГ, ИТХ |
| | ***Зорилт 2. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдлэг олгох, мэдээлэл түгээх, арга хэмжээний шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах*** | | | | | | | | | | | |
| *2.1* | *АХ2.2 МУХТЖҮЧ 6.4.2 УАӨДЗҮТ 2.7* | Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өртөмхий нийгмийн бүлгүүдийг тодорхойлж, тэдгээрийн амьжиргаанд гарч буй өөрчлөлтийн талаарх судалгааны ажлыг өргөжүүлэх | шинээр хийсэн судалгааны тоо | 0 | 1 | 1 | 1 | | 30 | 50 | 20 | БОГ, Сумын ЗДТГ, ОУБ, судалгаа-ны байгуул-лагууд |
| *2.2* | *АХ 2.2 МУХТЖҮЧ 2.2.2 УАӨДЗҮТ 2.10* | Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг иргэдэд мэдлэг олгох, мэдээллээр хангах орчинг бүрдүүлж, Сум бүр “Мэдээллийн төв”-тэй болж, чадавхжуулах сургалт арга хэмжээг зохион байгуулах | сумын тоо | 0 | 5 | 10 | 18 | | | 30 | 70 | БОГ, Сумын ЗДТГ, ОУБ |
| | | | Арга хэмжээний тоо | 0 | 4 | 8 | 12 | | | 30 | 70 | |
| *2.3* | *АХ 8.3 МУХТЖҮЧ 6.4.2 УАӨДЗҮТ 1.9* | Байгаль орчныг хамгаалан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож амьдрах экологийн боловсрол хүмүүжил олгох, соён гэгээрүүлэх арга хэмжээг бүх шатанд түгээн дэлгэрүүлэх | Хамрагдсан хүний тоо | 0 | 300 | 600 | 1000 | | 20 | | 80 | БОГ, СЗДТГ, сургалтын байгуул-лагууд |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | | Малчид, тариаланчдын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаарх мэдлэг, хандлагыг өөрчлөх, хариуцлагыг дээшлүүлэх | сургалтын тоо/хамрагдсан хүний тоо | 0 | 4сургалт /300 хүн | 8сургалт /600 хүн | 12 сургалт /900 хүн | | 20 | 30 | 50 | ХХААГ, БОГ, ЦУОШТ, СЗДТГ, сургалтын байгууллагууд |
| 2.5 | АХ 2.2 МУХТЖҮЧ 2.2.2 ОЭМҮХ 3.4.1 УАӨДЗҮТ 2.9 | "Уур амьсгалын өөрчлөлт, түүний үр дагавар хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь" сэдвээр хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг үе шаттай зохион байгуулах | сургалтын тоо/ жилд 2 удаа | 0 | 4 | 8 | 12 | 20 | 40 | 20 | 20 | ЭМГ, БШУГ, аймаг, сумын ЗДТГ |
| 2.6 | УАӨДЗҮТ 2.9 | Уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний үрэлгэн хэрэглээ, орчны бохирдол, доройтлыг бууруулах үйл ажиллагаанд хүүхэд, өсвөр үе, залуучуудыг оролцуулсан хөтөлбөр, хөгжлийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах | Үйл ажиллагаанд хамрагдсан оролцогчдын тоо | 0 | 1000 | 1000 | 1000 | 30 | 30 | 30 | 10 | Сумын ИТХ, ЗДТГ, ХГБХГ, БОГ |
| 2.7 | | Нийгэм ба зан үйлийн зэрэг өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн хүүхэд, залуучуудын манлайлал, оролцоотой, олон нийтийн санаачилгад тулгуурласан байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээ, хөтөлбөр, компанит үйл ажиллагааг зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 0 | 1000 | 1000 | 1000 | 30 | 30 | 30 | 10 | Сумын ИТХ, ЗДТГ, ХГБХГ, БОГ |
| 2.8 | АОББҮХ 5.4.1 | Эрчим хүчний хэмнэлттэй, нүүрс, зуухыг халсан, хүлэмжийн хийн ялгарал багатай Монгол гэрийн дулаалга, халаалтын багц бүтээгдэхүүн зэрэг шинэлэг технологиудын нийгэм, эдийн засгийн үр нөлөө, иргэдийн зан | Хамрагдсан хүний тоо | 0 | 250 | 250 | 250 | 20 | 30 | 30 | 20 | Сумын ИТХ, ЗДТГ, БОГ, ГХБХБГ |



1825010052 ☎ 9076298

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дадлын өөрчлөлтийн судалгааг явуулах | | | | | | | | | | |
| 2.9 | | Монгол гэрийн дулаалга, халаалтын багц бүтээгдэхүүн зэрэг эрчим хүчний хэмнэлттэй, нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарал багатай технологийг өрх, ААН-ийн түвшинд нэвтрүүлж, эдгээр жишиг төслүүдийг сумдад хэрэгжүүлэх | Төсөлд хамрагдсан өрхийн тоо | 55 | 20 | 50 | 100 | | 80 | | 20 | Аймаг, Сумын ЗДТГ |
| | ***Зорилт 3. Уур амьсгал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл, гамшгийн үүсэх эмзэг байдал, эрсдэлийг бууруулах, дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх.*** | | | | | | | | | | | |
| 3.1 | *АХ 7.3.19 МУХТЖҮЧ 6.4.2, 7.3.3 УАӨДЗҮТ 1.2* | Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлд суурилсан төлөвлөлтийн суурь мэдээлэл болох уур амьсгалын стандарт, нормыг шинэчлэх, аймгийн уур амьсгалын лавлах эмхтгэлийг боловсруулах | гүйцэтгэл, % | 1986 онд хэвлэгдсэн | Боловсруулж гаргасан байна. | - | - | | 50 | 50 | | ЦУОШТ, дэд бүтцийн салбарууд |
| 3.2 | *АХ 6.4.13 7.3.20 МУХТЖҮЧ 6.4.3 УАӨДЗҮТ* | Ус, цаг агаар, уур амьсгалын гамшигт үзэгдлийн ажиглалт, хяналт шинжилгээний сүлжээг сайжруулж, өргөтгөх | Доплер радерын сүлжээний тоо | Байхгүй | - | - | 1 станц | 80 | | 20 | | БОГ, ЦУОШТ, ОБГ |
| | | | Шинээр байгуулсан салбарын тоо | 25 салбартай | 1харуул | 1 харуул | 1 харуул | 40 | | 60 | | БОГ, ЦУОШТ |
| 3.3 | *АХ 6.4.13 7.3.20 МУХТЖҮЧ 6.4.3 АЗДҮАХ 3.3.3.2.* | Багц мэдээ үйлчилгээг сайжруулах, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс ард иргэдийг сэрэмжлүүлж хохирол багатай даван туулах арга хэмжээг зохион байгуулах | Мэдээлэл хүлээн авсан хэрэглэгчдийн тоо | 6000-7000 хэрэглэгчид | 10000-11000 хэрэглэгчид | 11000-12000 Хэрэглэгчид | 12000-13000 Хэрэглэгчид | 100 | | | | ОБГ, УЦУОШТ |
| 3.4 | *АХ 9.2.6 МУХТЖҮЧ 6.4.3 АЗДҮАХ 3.3.3.2.* | Хур тунадас нэмэгдүүлэх шинжлэх ухааны оновчтой арга технологийг нэвтрүүлэх | Үйл ажиллагаа явуулсан тоо | 2 экспедици ажиллаж байна | 14 аас доошгүй удаа явуулах | 14 аас доошгүй удаа явуулах | 14 аас доошгүй удаа явуулах | 50 | 50 | | | БОГ, УЦУОШТ |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *3.5* | *АЗДҮАХ 3.3.3.2.* | Агаарын чанарын хяналтын давтамжийг нэмэгдүүлж иргэдийг бодит мэдээллээр шууд хангах | Хяналтын тоо хэмжээ, мэдээлэл хүргэсэн тоо | Өдөр 2-3 удаа хяналт хийж, мэдээллийг 7 хоногт 1 удаа хүргэдэг | Өдөрт 24 удаа, өдөр бүр буюу 7 хоногт 7 удаа мэдээлэл хүргэнэ. | Өдөрт 24 удаа, өдөр бүр буюу 7 хоногт 7 удаа мэдээлэл | Өдөрт 24 удаа, өдөр бүр буюу 7 хоногт 7 удаа мэдээлэл | 50 | 50 | | | УЦУОШТ |

| *№* | *Бодлогын үндэслэл* | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн үзүүлэлт буюу хүрэх түвшин | | | | Санхүүгийн эх үүсвэр, хувиар | | | | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин 2024 он | 2025-2026 он | 2027-2028 он | 2029-2030 он | УТ | ОНТ | ТХ | ОТ | |
| | **Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах стратеги чиглэл: ГАЗРЫН ДОРОЙТОЛ, ЦӨЛЖИЛТ** | | | | | | | | | | | |
| ***Зорилт 4. Газрын доройтол, цөлжилтийг сааруулах, бэлчээрт ашиглагдаж буй газрын даац хэтрэлтийг бууруулах, бэлчээр, хөрсний хүлэмжийн хийг шингээх чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авах*** | | | | | | | | | | | | |
| *4.1* | *АХ 6.2 МУХТЖҮЧ 6.4.2 УАӨДЗҮТ 4.0* | Хүчтэй, нэн хүчтэй цөлжилтэд өртсөн газар нутгийг хашиж хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах | Нөхөн сэргээх арга хэмжээ авсан талбай, га | 0 | 5 | 10 | 15 | | 40 | 30 | 30 | БОГ, ГХБХБГ, аймаг, сумын ЗДТГ, малчид |
| *4.2* | | Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх | Нийт газар нутагт эзлэх хувь, % | 46.4 | 47.3 | 47.6 | 48.0 | | | | | БОГ, сумын ЗДТГ, ТХГЗ |
| *4.3* | *АХ 6.2.8 6.2.9 МУХТЖҮЧ 6.2.4 УАӨДЗҮТ 4.1, 4.4, 10.1,* | Цөлжилтөөс хамгаалах ойн зурвас байгуулах | хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 1 | 2 | 3 | 4 | | 40 | 30 | 30 | БОГ, СЗДТГ, Ойн анги |
| | | | Нэмэгдүүлсэн ойн зурвасын хэмжээ, га | 22.5 га | 30 га | 40 га | 50 га | | 40 | 30 | 30 | |
| *4.4* | | Бэлчээрийн доройтолд орж сэргэх чадвар муудсан газрыг хашиж, тухайн газрын унаган үет болон навчит ургамлын үрийг нэмэрлэн тарих, дахин суулгах | үр тариалсан газар нутгийн хэмжээ, га | 0 | 5 | 10 | 15 | | 40 | 20 | 40 | ГХБХБГ, ХХААГ, СДТГ, малчин иргэд |



1825010052 9076298

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *4.5* | | Бэлчээрийн даац хэтэрсэн сумдад бэлчээрийг улирлаар сэлгэн ашиглах тогтолцоог нэвтрүүлэх | туршилтын тоо | 0 | 5 | 10 | 20 | | 20 | | 80 | СЗДТГ, ХХААГ, малчид |
| *4.6* | *АХ 8.3.4 МУХТЖҮЧ 8.3.3 ҮТХНЗХАХТ 3.1.2 УАӨДЗҮТ 10.3* | Уст цэг хүрэлцээгүй бэлчээрийн газарт гадаргын ус нэмэгдүүлэх хөв цөөрөм байгуулах, худаг ус гаргах | тоо | 2 | 1 | 1 | 1 | 20 | 40 | 30 | 30 | БОГ, ХХААГ, СДТГ, малчин иргэд |
| | ***Зорилт 5. Газар ашиглалтын сөрөг нөлөөллөөс үүдэлтэй газрын доройтлыг бууруулах*** | | | | | | | | | | | |
| *5.1* | *АХ 6.2 3.6.1 МУХТЖҮЧ 3.6.3 АЗДҮАХ 3.3.1.4* | Уул уурхайн томоохон компаниудын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газруудын судалгаа хийж, байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартын түвшинд хийж, хэвшүүлэх | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | 333 га эвдэрсэн | 50 га | 50 га | 50 га | 10 | 30 | 30 | 30 | БОГ, СЗДТГ, Уул уурхайн компа-нууд |
| *5.2* | | Эзэнгүй орхигдсон талбайг нөхөн сэргээх, мэдээллийн сан үүсгэх | нөхөн сэргээсэн талбайн хэмжээ, га | 2 | 15 | 30 | 50 | 10 | 30 | 30 | 30 | БОГ, Стат/Х |
| *5.3* | | Автозам, бүтээн байгуулалтын явцад эвдэрсэн газар нутгийг нөхөн сэргээх, доройтлыг бууруулах | нөхөн сэргээсэн хэмжээ, га | 2024 онд 117 га | Тухайн жилийн эвдрэлээс шалтгаална | | | | 20 | | 80 | БОГ, СЗДТГ, ГХБХБГ |
| | ***Зорилт 6. Хог хаягдлаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах*** | | | | | | | | | | | |
| *6.1* | *АХ 6.4.5 МУХТЖҮЧ 6.4.4, 6.4.6 ҮТХНЗХАХТ 1.6 АЗДҮАХ 3.3.5.1* | Бүх сумын төвлөрсөн хогийн цэгт байгаль орчны үнэлгээ хийлгэж, стандарт шаардлага хангуулах арга хэмжээг авсан байх | стандарт шаардлага хангасан цэгийн тоо | 1 | 5 сум | 10 сум | 18 сум | | | 50 | 50 | БОГ, СЗДТГ |
| *6.2* | | Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах тохиромжтой байршлын судалгаа ба ТЭЗҮ боловсруулах | судалгааны тоо | 0 | судалгаа эхлүүлэх | ТЭЗҮ хийсэн байна. | 1 судалгаа хийгдсэн байна. | | | 50 | 50 | БОГ, СЗДТГ, АЗДТГ |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.3 | | Хатуу, шингэн хог хаягдлаас ялгарч буй хүлэмжийн хий, түүний уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, ил задгай хаягдах хог хаягдлын хэмжээг бууруулах | Сургалт, нөлөөллийн ажлын тоо | жилд 2 удаа | 2 | 4 | 6 | | | | 100 | БОГ, СЗДТГ, сургалт, судалгаа ныбайгуу ллагууд |
| 6.4 | | Саарал ус хэрэглэх боломжтой байгууллага, ААН-ийг тодорхойлох, хэрэглээг дэмжих | Саарал усны хэрэглээ нэмэгдсэн хувь | 0 | 5 | 10 | 15 | | 50 | | 50 | БОГ, ГХБХБГ, ААНБ |
| ***Зорилт 7. Ойн салбарыг хөгжүүлэх, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх*** | | | | | | | | | | | | |
| 7.1 | АХ 6,2,4 МУХТЖҮЧ 6.4.2 УТХНЗАХТЗ.4 УАӨДЗҮТ | Мод үржүүлгийн болон тарьц суулгац ургуулах технологийг сайжруулах, усалгааны системийг автоматжуулах, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх | нэвтрүүлсэн технологийн тоо | 1 | 2 | 5 | 7 | | 40 | 20 | 40 | БОГ, ойн анги, ойн аж ахуйн байгуулл агууд |
| 7.2 | АХ 6.2.4 9.2.8 УАӨДЗҮТ 7.1 АЗДҮАХ 3.3.2.1 | Орон нутгийн уур амьсгалын онцлогт тохирсон таримал, сортуудын үрийг үржүүлдэг үрийн аж ахуйг нэмэгдүүлэх | бэлтгэх үрийн хэмжээ тн/жил | 2 тн | 0.1-0.2 тн | 0.2-0.3 тн | 0.3-0.4 тн | 10 | 40 | | 50 | БОГ, СЗДТГ ойн анги, аж ахуйн нэгжүүд |
| 7.3 | | Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагууд, агро ойн аж ахуйнуудыг дэмжих замаар ойн сангийн талбайг нэмэгдүүлэх | Нэмэгдүүлсэн ойн сангийн талбай, хувь | ойн сан 0.02 % | 0.01 % | 0.02 % | 0.04 % | | 40 | | 60 | |
| 7.4 | АХ 6.1.3 6.2.4, 9.2.5 МУХТЖҮЧ 6.2.5 УАӨДЗҮТ 7.3 АЗДҮАХ 3.3.2.2 | Байгалийн ойг арчилж, хамгаалах, хөнөөлт шавьж, өвчний хөнөөлийн голомттой тэмцэж ойг хамгаалах, сэргэн ургах чадавхийг нэмэгдүүлэх | нэмэгдүүлсэн ойн талбай, га | 2024 онд 64 га | 20 га | 20 га | 20 га | 10 | 30 | 40 | 20 | СЗТГ, Сум дундын ойн анги |
| 7.5 | АХ 6.2.4 МУХТЖҮЧ 6.2.5 УТХНЗХАХТ 4.2 УАӨДЗҮТ 7.2 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, ойжуулалт хийх, төв суурин газрын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх | Нэмэгдүүлсэн талбайн хэмжээ, хувь | 86.87 га | 5% | 10% | 15% | | 80 | | 20 | БОГ, Сум дундын ойн анги аймаг, |

1825010052 9076298

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7.6 | *АЗДҮАХ 3.3.2.2* | Авто зам, уул уурхайн олборолт, үйлдвэрлэл, бүтээн байгуулалт явагдаж байгаа газруудад мод тариалж, ойн зурвас байгуулах | нэмэгдүүлсэн ойн зурвасын талбай, га | 22.5 га | 30 | 40 | 50% | | 40 | | 60 | БОГ, сумын ЗДТГ, дэд бүтцийн салбар |
| | **Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах стратеги чиглэл: ДЭД БҮТЭЦ, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ** | | | | | | | | | | | |
| ***Зорилт 8. Эрчим хүчний хангамжийн үр ашгийг сайжруулах замаар хүлэмжийн хийг бууруулах, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх*** | | | | | | | | | | | | |
| 8.1 | *АХ 3.3.5 9.2.4 АЗДҮАХ 3.2.3.3* | Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг дэмжих, одоо байгаа хүчин чадлыг нэмэгдүүлэх, нарны эх үүсвэрийн тоог нэмэгдүүлэх | нэмэгдүүлсэн тоо, хувь | 0 | 5% | 10% | 15% | | 40 | 40 | 20 | аймаг, сумын ЗДТГ ИТХ ЭХГ |
| 8.2 | | Газрын гүний дулааны эх үүсвэрийг ашиглан халаалтын системийг шийдэх боломжийг сумд, алсагдсан багуудад турших | туршсан багын тоо | 0 | 1 баг | 2 баг | 4 баг | | 20 | 40 | 40 | аймаг, сумын ЗДТГ, дэд бүтцийн салбар, ОУБ |
| 8.3 | *АХ 2.5.1 МУХТЖҮЧ 2.5.6 АЗДҮАХ 2.4.3.1* | Зам, гүүр, үерийн хамгаалалтын барилгуудын ус өнгөрөөх чадавхыг мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, бүрэн засварлах | засварласан үерийн хамгаалалтын тоо | 2 | 2 | 2 | 2 | 20 | 60 | | 20 | аймаг, сумын ЗДТГ, дэд бүтцийн салбар |
| 8.4 | *АХ 8.2 9.5.3 МУХТЖҮЧ 3.3.4, 8.2 АЗДҮАХ 3.2.8.1* | Байгалийн үзэсгэлэнт газар, нуур, рашаан сувилалыг түшиглэн стандартад нийцсэн амралт, сувиллын тохилог газруудыг байгуулах | Шинээр байгуулсан амралт, сувиллын газрын тоо | 2 | 2 | 3 | 4 | | 20 | | 80 | Сумын ЗДТГ, ИТХ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |
| 8.5 | | Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуучлал хөгжүүлэх, дүрэм журам болон машрутыг батлах | хөгжүүлсэн машрутын тоо | 0 | 1 | 2 | 3 | | 20 | | 80 | СЗДТГ, ТХГЗ, СУАЖЗГ |
| 8.6 | *АХ 2.5.2 6.4 МУХТЖҮЧ 6.4.2, 8.2* | Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд бүрэн хамруулж, эко | үнэлгээнд хамруулсан аж ахуй нэгж | 3 | 15 | 30 | 50 | | | | 100 | БОГ, Сумын ЗДТГ, |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *АЗДҮАХ 3.2.8.1* | ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг хэрэгжүүлэх. | байгууллагын тоо, хувь | | | | | | | | | аж ахуйн нэгжүүд |
| *8.7* | | | ариун цэврийн байгууламжийн тоо, хувь | 15 | 50 | 75 | 100 | | | | 100 | |
| *8.8* | *АЗДҮАХ 2.4.2.1* | Төв суурин газрын дэд бүтцийг сайжруулж, төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд ААН, байгууллага, айл өрхийн хэрэглэгчдийг холбох | Дэд бүтцэд холбогдсон ААН, байгууллага, айл өрхийн тоо | 0 | 70 | 80 | 100 | | | | 100 | Аймаг, Сумын ЗДТГ, дэд бүтцийн салбар, айл өрх, ААНБ |
| *8.9* | *АЗДҮАХ 3.2.3.1* | Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр, ЦДАШ, дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, ААНБ, айл өрхийн халаалтыг ЦЭХ-ээр шийдэхийг дэмжих | Халаалтаа цахилгаанаар шийдсэн ААН, байгууллага, айл өрхийн эзлэх хувь | 5% | 10% | 20% | 30% | | | | 100 | Аймаг, Сумын ЗДТГ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд, айл өрх |
| *8.10* | *АЗДҮАХ 3.2.8.1* | Аялал жуулчлалын кэмп, гэр сууцуудыг хүлэмжийн хийн ялгарал багатай, эрчим хүчний хэмнэлттэй шийдлээр хэрэглээгээ шийдвэрлэхэд нөлөөлж, шийдлүүдийг нэвтрүүлэх | СЭХүчээр хэрэглээгээ шийдсэн ААН-ийн тоо | 0 | 10 | 20 | 30 | | | | 100 | СЗДТГ, ААНБ |

| № | *Бодлогын үндэслэл* | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн үзүүлэлт буюу хүрэх түвшин | | | | Санхүүгийн эх үүсвэр, хувиар | | | | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин 2024 он | 2025-2026 он | 2027-2028 он | 2029-2030 он | УТ | ОНТ | ТХ | ОТ | |
| | **Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги чиглэл: МАЛ АЖ АХУЙ, БЭЛЧЭЭР** | | | | | | | | | | | |
| | ***Зорилт 9. Хүлэмжийн хийн ялгарал багатай, бэлчээр усны нөөцөд нийцсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, эрсдэл даах чадавхтай, бүтээмжтэй мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх*** | | | | | | | | | | | |
| *9.1* | *АХ 8.3.4 МУХТЖҮЧ 8.3.11 УАӨДЗҮТ* | Малчин өрхийн өвөлжөө-хаваржааны бууцны хөлд тэжээлийн ургамал тарих замаар малчин өрхийн түвшинд өөрийн | тэжээл тариалсан малчин өрхийн тоо | нийт 9178 малчин өрх | нийт малчны 5% | нийт малчны 10% | нийт малчны 15% | | 50 | 10 | 40 | СЗДТГ, ХХААГ, малчид |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 10.4 | бэлтгэх тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх | | | | | | | | | | |
| 9.2 | АХ 8.3.4 МУХТЖҮЧ 8.3.11 УАӨДЗҮТ 10.5 АЗДҮАХ 3.2.5.1, 3.2.6.3 | Өвс, тэжээлийн бөөний худалдаа, нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх | нэмэгдүүлсэн тэжээлийн нөөцийн хэмжээ, хувь | 0 | 5% | 10% | 15% | | 50 | | 50 | Сумын ЗДТГ, ХХААГ, малчид |
| 9.3 | | Сумдын тариаланд тохиромжтой атар болон атаршсан талбайг эргэлтэд оруулах замаар тэжээлийн ургамал тариалах талбайг нэмэгдүүлэх | тариалсан талбайн хэмжээ, га | 2987 га атаршсан талбайг эргэлтэд оруулсан | 100 га | 100 га | 100 га | | 40 | 20 | 40 | Сумын ЗДТГ, ХХААГ, малчид |
| 9.4 | | Бэлчээрийн хөнөөлт, хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулах, олон нийтийн оролцоог хангах | тэмцсэн талбай хэмжээ, га | 30.0 мян.га | 10.0 мян.га | 15.0 мян.га | 20.0 мян.га | | 30 | 20 | 50 | Аймаг, сумын ЗДТГ, ХХААГ, малчид |
| 9.5 | АХ 8.3.4 МУХТЖҮЧ 8.3.11 УАӨДЗҮТ 10.6 АЗДҮАХ 3.2.4.1 | Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийг бууруулах "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, % | 0 | 20 | 30 | 50 | 50 | 50 | | | ХХААГ, аймаг, сумын ЗДТГ, малчид |
| | ***Зорилт 10. Мал сүргийн чанар, эдийн засгийн эргэлтийг сайжруулж, бэлчээрийн ачааллыг бууруулах*** | | | | | | | | | | | |
| 10.1 | АХ 8.3.18 УАӨДЗҮТ 11.4 | Малын шилжилт хөдөлгөөн, гарал үүслийн бүртгэлийг мөшгөх технологи нэвтрүүлэх | нэвтрүүлсэн сумын тоо | 0 | 2 | 3 | 5 | 10 | 20 | 10 | 60 | СЗДТГ, ХХААГ |
| 10.2 | АХ 8.3.31 6.2.12 МУХТЖҮЧ 8.3.4 УАӨДЗҮТ 11.0 АЗДҮАХ 3.2.6.2 | Малын үүлдэр угсаа сайжруулан өндөр ашиг шимт цэвэр, баталгаажсан үүлдэрийн малын тоог нэмэгдүүлэх | нийт малын тоотой харьцуулсан цэвэр, баталгаажсан үүлдэрийн малын тоо, хувь | Нийт малын 1,9 % | 2% | 4% | 6% | | 20 | | 80 | сумын ЗДТГ, ХХААГ, малчид |
| 10.3 | АХ 8.3:4 6.2.12 МУХТЖҮЧ 8.3 | Ноос, ноолуур, амьд мал, мах, түүхий эдийг биржийн худалдаагаар зуучлан борлуулах сүлжээг нэмэгдүүлэх | сүлжээний тоо | - | 3 | 5 | 10 | | 20 | | 80 | СЗДТГ ХХААГ, малчид |

1825010052 9076298

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *10.4* | *УАӨДЗҮТ 11.1 АЗДҮАХ 3.2.6.1* | Сум бүрт мал нядалгааны газар, арьс ширний анхан шатны тордолт хийх цех байгуулж, мал, мах бэлтгэл, технологийн тээвэр бүхий борлуулалтын нэгдсэн сүлжээ бий болгох | цех, мал борлуулах цэгийн тоо | - | 5 | 10 | 18 | | 20 | | 80 | ХХААГ, Сумын ИТХ, ЗДТГ, малчид |
| *10.5* | *АХ 8.3.5 8.3.7 АЗДҮАХ 3.2.7.3 АЗДҮАХ 3.2.6.1* | Мал эмнэлэг болон малчдын хамтын ажиллагааг сайжруулж, халдваргүйжүүлэх, вакцинжуулах ажлыг эрчимжүүлэх | вакцинд хамрагдсан малын эзлэх хувь | 79.5 | 80 | 80 | 80 | 50 | 50 | | | МЭГ, СЗДТГ, малчид |
| *10.6* | | Сумдад мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослуулсан нэгдсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх | фермерийн тоо | 1 | 2 | 3 | 5 | | | 20 | 80 | СЗДТГ тариалан ч, малчид |
| | **Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги чиглэл: Газар тариалан** | | | | | | | | | | | |
| | ***Зорилт 11. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, усалгаатай тариаланг нэмэгдүүлэх, хөрсний чийгийн ууршилтыг бууруулж, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах*** | | | | | | | | | | | |
| *11.1* | *АХ 8.3.23 МУХТЖҮЧ 6.2.1, 8.3.1 8.3.6 УАӨДЗҮТ 12.2 АЗДҮАХ 3.2.5.1* | Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, ээлжлэн тариалах системийг туршиж хэвшүүлэх, цулгай уриншийн эзлэх хувийг бууруулах | туршсан талбайн хэмжээ, га-гаар | 50 га | 60 га | 70 га | 70 га | | | | 100 | ХХААГ, тариалан эрхлэгчид |
| *11.2* | | Усалгаагүй талбайг тэглэж, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх | тэглэсэн талбайн хэмжээ га-аар | 50 га | 100 га | 150 га | 200 га | | | | 100 | ХХААГ, тариалан эрхлэгчид |
| *11.3* | *АХ 8.3. 6.2.9, 6.2.4 МУХТЖҮЧ 8.3.1,6.25 ҮТХНЗХАХТ. 22 УАӨДЗҮТ 12.6 АЗДҮАХ 3.2.5.1* | 5 га-аас их талбайтай тариалангийн газруудад хамгаалалтын ойн зурвас байгуулах | зурвас байгуулсан талбай, га | 13.6 га | 50 га | 100 га | 150 га | | | 20 | 80 | Сумын ЗДТГ, ХХААГ, тариалан эрхлэгчид |
| *11.4* | | Төмс хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлд дуслын усалгаа болон эко нийлэг хальсан хучлагын технологи нэвтрүүлэх | технологи нэвтэрсэн талбайн хэмжээ, га | 0 | 1 га | 1,5 га | 2 га | 10 | 10 | 20 | 60 | Сумын ЗДТГ ХХААГ, тариалан эрхлэгчид |
| *11.5* | *АХ 8.3.25 МУХТЖҮЧ 8.3.1 УАӨДЗҮТ 13.3* | Ган, өвчин, хортонд тэсвэртэй таримал, сортуудыг нутагшуулж, сортын үрийн хангамжийг сайжруулах | тариалангийн талбайтай харьцуулсан нутагшуулсан | 0 | 1 | 1 | 2 | 30 | 20 | 20 | 30 | ХХААГ тариалан эрхлэгчид, судалгааны |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | АЗДҮАХ 3.2.5.1 | | талбайн хэмжээ, хувь | | | | | | | | | байгууллага |
| 11.6 | АХ 8.3.6 МУХТЖҮЧ 8.3 УАӨДЗҮТ 13.4 АЗДҮАХ 3.2.5.1 | Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих, санхүүгийн туслалцаа үзүүлэх, ногоон зээлд хамруулах | дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж, иргэн тоо | 1 | 2 | 2 | 2 | | | 20 | 80 | Аймаг, сумын ЗДТГ, ХХААГ тариалан эрхлэгчид, судалгааны байгууллага |
| 11.7 | | Чацаргана, улаан хальст сармис, хунчир, чихэр өвс, эмийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлж бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих, аймгийн бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх | бүтээгдэхүүний тоо | 2 | 3 | 4 | 5 | | | 20 | 80 | |
| | **Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги чиглэл: Экосистем, биологийн олон янз байдал** | | | | | | | | | | | |
| ***Зорилт 12. Биологийн олон янз байдлыг хамгаалах, зориудаар өсгөн үржүүлж, тарималжуулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах*** | | | | | | | | | | | | |
| 12.1 | АХ 6.2.2 МУХТЖҮЧ 6.1.2, 6.2.2 УАӨДЗҮТ 3.5 АЗДҮАХ 3.3.1.2 | ОУ-ын улаан данс (IUCN 2001)-ны шалгуураар амьтан, ургамлын зүйлүүдийн ховордлын зэргийг үнэлж, ховордсон зүйлийг хамгаалах арга замыг тодорхойлж, хэрэгжүүлэх | үнэлгээ хийсэн ургамал, амьны тоо | 0 | 1 | 1 | 2 | 40 | 20 | 20 | | БОГ, мэргэжлийн байгууллага |
| 12.2 | АХ6.1.2 МУХТЖҮЧ 6.1.2 ҮТХНЗХАХТ 3.5.2 УАӨДЗҮТ 3.6 АЗДҮАХ 3.3.1.2 | Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнийг хянах мониторингийн сүлжээ бий болгох, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх | мониторингийн цэгийн тоо | 0 | 2 цэг | 3 цэг | 5 цэг | | 50 | 30 | 20 | БОГ, СЗДТГ, ТХГЗ |
| 12.3 | | Нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтыг шинэчилэн батлуулах | гүйцэтгэл хувиар,% | ЗГ батална | - | | | | | | | БОГ, СЗДТГ, ТХГЗ |
| 12.4 | АХ6.1.4 МУХТЖҮЧ 6.1.1 УАӨДЗҮТ 3.1 | Аймгийн хэмжээнд тархан ургадаг ач холбогдол бүхий ургамлын төрөл зүйлийн экологи-эдийн засгийн үнэлгээ, судалгаа хийх | үнэлгээ судалгааны тоо | 2022 онд хийгдсэн хийх шаардлагагүй | - | - | - | | | | | БОГ, Мэргэжлийн байгууллага |

1825010052 ☎.9076298

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12.5 | АЗДҮАХ 3.3.1.1 | Биологийн нэн ховор, ховор төрөл зүйл тархан амьдардаг тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх | Нийт талбайтай харьцуулсан хувь | Аймгийн нийт нутгийн 46.4 | 47.3 | 47.6 | 48.0 | | 30 | 40 | 30 | БОГ, ТХГЗ, Сумын ИТХ, ЗДТГ |
| 12.6 | АХ6.2.3 МУХТЖҮЧ 6.2.2 УАӨДЗҮТ 3.4 АЗДҮАХ 3.3.1.2 | Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, зориудаар нэн ховор, ховор амьтанг өсгөн үржүүлэх, устаж буй амьтны зүйлийн тоо толгойг нэмэгдүүлэх | Нутагшуулсан амьтны тоогоор | 2024 онд 70 | 50 | 50 | 50 | 20 | 40 | 20 | 20 | БОГ, ТХГЗ, СЗДГ, Олон нийт |
| 12.7 | | Ховордож буй амьтны амьдрах орчинг сайжруулах, холбоос нутгийг хамгаалалтад авах | хэрэгжүүлсэн арга хэмжээ | 0 | 1 | 2 | 3 | | 40 | 30 | 30 | Сумын ЗДТГ, БОГ |
| ***Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги чиглэл:* Усан хангамж, ундны усны аюулгүй байдал** | | | | | | | | | | | | |
| ***Зорилт 13. Гадаргын усны нөөцийн хуримтлалыг бий болгох, булаг шандын эхийг хамгаалах, усан хангамж, хүрэлцээг оновчтой зохион байгуулах менежментийг сайжруулах*** | | | | | | | | | | | | |
| 13.1 | АХ 6.3.9-11 МУХТЖҮЧ 6.3.2 УАӨДЗҮТ 6.4 АЗДҮАХ 3.3.4.1 | Аймгийн хэмжээнд гадаргын болон гүний усны эх үүсвэр, нөөцийн нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийх | Хайгуул судалгааны тоо | 1 | 1 | 2 | 3 | | 50 | 30 | 20 | Аймаг, сумын ЗДТГ, ИТХ |
| 13.2 | | Газар доорх усны нөөцийг нөхөн сэлбэх байгууламж (МАР), далд усан сан, нэвчүүлэх цооног байгуулах зэрэг төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх | МАР байгууламжийн тоо | 0 | - | 1 | 2 | | 40 | 10 | 50 | БОГ, СГЗахирг аад, СЗДТГ |
| 13.3 | АХ 6.3 МУХТЖҮЧ 6.3 УАӨДЗҮТ 6.0 | Цэвдгийн хайлалтыг бууруулах дэвшилтэт технологи, аргыг турших, хэрэгжүүлэх | хэрэгжүүлсэн арга хэмжээ | 0 | 1 | 2 | 3 | | 40 | 30 | 30 | БОГ, ЦУОШТ, ТХ, Мэргэж лийн байгуул лагууд |
| 13.4 | АХ 6.3.10 6.3.11, 9.2.19 МУХТЖҮЧ 6.3.2 УАӨДЗҮТ | Усалгаатай газар тариаланд шаардлагатай усны нөөцийг бүрдүүлэх, цас, бороо, шар усны үерийг хуримтлуулах хөв цөөрөм, усан санг байгуулах | Шинээр байгуулсан хөв цөөрмийн тоо | 3 | 3 | 3 | 3 | 30 | 30 | 30 | 10 | ХХААГ, СЗДТГ, ААНБ |

1825010052 9076298

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *13.5* | *6.5 АЗДҮАХ 3.3.4.1* | Экосистемийн хувьд өөрчлөлтөд орж элсний нүүлтэнд дарагдаж усны түвшин буурсан томоохон нууруудыг хамгаалах нөхөн сэргээх ажлын ТЭЗҮ боловсруулах | ТЭЗҮ боловсруулж, арга хэмжээ авсан нуурын тоо | 2 Аварга тосон нуур, Гурван нуур | 1 | 2 | 2 | 20 | 40 | 20 | 20 | БОГ, ЗДТГ, СГЗ |
| *13.6* | *АХ 6.3 МУХТЖҮЧ 6.3 УАӨДЗҮТ 6.6* | Хатаж ширгэж буй нуурын эх үүсвэрүүдийг нөхөн сэргээж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах | сэргээсэн нуурын тоо | 1 | 2 нуур | 2 нуур | 2 нуур | 10 | 40 | 40 | 10 | Сумын ЗДТГ, БОГ, СГЗ |
| *13.7* | *АХ 6.3 МУХТЖҮЧ 6.3.3, 6.3.4 АЗДҮАХ 3.3.4.1* | Ус ашиглалтын хэрэглээ болон бэлчээрийн даацтай уялдуулан худаг гаргах, ундны усны худагт ус цэнгэгжүүлэх зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах, инженерийн хийцтэй худгийн тоог нэмэгдүүлэх | малчинд зориулсан худгийн тоо | 31 | 10 худаг | 10 худаг | 10 худаг | 10 | 40 | 30 | 20 | СЗДТГ, БОГ, ХХААГ, малчин иргэд |
| | | | малд зориулсан худгийн тоо | | 10 худаг | 10 худаг | 10 худаг | 10 | 30 | 40 | 40 | |
| *13.8* | | Ус түгээх байгууламжийг сайжруулах, усны нөөц хомс сумдад усны хүртээмжийг нэмэгдүүлэх | ус түгээх байгууламжийн тоо | ..... | .... | .... | .... | | 50 | | 50 | Сумын ЗДТГ, ГХБХБГ |
| *13.9* | *АХ 6.3.4 МУХТЖҮЧ 6.3.1 АЗДҮАХ 3.3.4.1* | Ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоож, тохижуулах, булаг, шандны эхийг хашиж хамгаалах | Тоо 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 40 | 20 | 20 | БОГ, сумын ЗДТГ |
| *13.10* | | Аялал жуулчлалын баазуудын усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих | хамгаалалтын бүс тогтоосон баазын тоо | 0 | 3 | 5 | 7 | | 20 | 20 | 40 | БОГ, Сумын ЗДТГ, ААНБ |
| *13.11* | | Уул уурхайн усны ашиглалтад газрын доорх усыг хэмнэлттэй үр ашигтай ашиглах зорилгоор усны тоолуур суурилуулах, саарал усыг эргүүлэн ашиглах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх | саарал усыг эргүүлэн ашиглаж буй уул уурхайн тоо | 3 | 5 | 10 | 15 | | | | 100 | БОГ, сумын ЗДТГ, СГЗ, уул уурхайн компаниуд |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *13.12* | *АЗДҮАХ 2.2.1.6* | Сум, багийн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагад аюулгүй, тэгш хүртээмжтэй, жендерийн мэдрэмжтэй байдлаар Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн (УХАЦЭА) үйлчилгээ, байгууламжийг нэмэгдүүлэх | Нэмэгдүүл сэн байгуулам жийн тоо | 8 | 10 | 10 | 10 | 30 | 40 | 20 | 10 | сумын ЗДТГ, ОУБ-ын төсөл хөтөлбөр, бусад |
| | ***Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги чиглэл*: Нийгэм, иргэдийн амьжиргаа** | | | | | | | | | | | |
| | ***Зорилт 14. Уур амьсгалын өөрчлөлтөд өртөж болзошгүй эмзэг бүлгийг тодорхойлж, дасан зохицох арга хэмжээг нэмэгдүүлэх*** | | | | | | | | | | | |
| *14.1* | *АХ 3.4 МУХТЖҮЧ 8.3.15 УАӨДЗҮТ 15.5* | Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, ногоон ажлын байр бий болгох, энэ чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх | хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тоо | 12 | 15 | 20 | 30 | 20 | 50 | | 30 | Аймаг, сумын ЗДТГ, ИТХ, ХХҮГ, төсөл хөтөлбөр |
| *14.2* | *АХ 2.1 МУХТЖҮЧ 3.3.3 8.3.14 УАӨДЗҮТ 15.1* | Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өртөмтгий зорилтод бүлэг болон байгалийн гамшигт үзэгдлийн улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдаж, суурин газарт шилжин ирсэн иргэдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах | сургалтын тоо/ хамрагдсаг иргэдийн тоо | 0 | 1/20 | 2/40 | 2/40 | | 50 | | 50 | Аймаг, сумын ЗДТГ, ХХҮГ, сургалт, судалгааны байгуул-лагууд |
| *14.3* | *АХ 3.1, 9.2 МУХТЖҮЧ 6.2.3, 6.4.2 8.1.4 АЗДҮАХ 3.3.3.2, 2.1.3.1, 3.3.1.3* | Цаг агаарын гамшигт үзэгдлийн талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх | Сургалт мэдээлэл тоо/ хамрагдсан хүний тоо /жилд/ | 24/1200 | 48/2400 | 48/2400 | 48/2400 | | | 40 | 60 | ЦУОШТ, ОБГ |
| *14.4* | | Малчдыг нийгмийн даатгалд хамруулах замаар уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий эмзэг бүлгийг дасан зохицуулах | Нийгмийн даатгалд хамрагдалт, нэмэгдүүлсэн хувиар | 0 | 10 | 15 | 20 | | | | 100 | НДГ, малчид |
| *14.5* | | Экологийн тэнцвэрт байдлын тухай цогц ойлголт, мэдлэгийг олгох, экосистемийг хамгаалахад олон талт оролцоог бий болгох | хамрагдсан хүний тоо/үйл ажиллагааны тоо | 121/1 | 100/2 | 200/4 | 300/6 | | | 20 | 80 | БОГ, бусад байгуулла-гууд |

1825010052 ± 9076298

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *14.6* | *АОББҮХ 5.4.1* | Монгол гэр, хувийн орон сууцанд амьдардаг айл өрхүүдэд дулаан алдагдлаа бууруулахын ач холбогдлыг таниулан сурталчлах, агаарын бохирдлыг бууруулах ЧИП гм шинэлэг технологиудын талаар мэдээллийн төв, ТВ, нийгмийн сүлжээгээр цацахыг дэмжих | Сурталчилгаа, мэдээлэл түгээсэн үйл ажиллагааны тоо | 10 | 20 | 30 | 50 | | | | 100 | аймаг, СЗДТГ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |
| *14.7* | *АОББҮХ 5.4.1* | Дулаан алдагдлаа багасгаж, агаарын бохирдлыг бууруулах ЧИП багцын хэрэглээг нэмэгдүүлэх, ашиглагч айл өрх, ААН, байгууллагыг урамшуулах | Агаарын бохирдлоо бууруулсан ААН, байгууллага, айл өрхийн тоо | 55 | 20 | 50 | 100 | | | | 100 | Аймаг сумын ИТХ, ЗДТГ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |
| *14.8* | *АЗДҮАХ 3.3.3.2* | Нийтийн эзэмшлийн зам талбайд цаг агаар, байгалийн гамшигт үзэгдлийн анхааруулга, агаарын чанарын мэдээлэл дамжуулах самбар байршуулж олон нийтэд мэдээлэл хүргэх | Мэдээллийн самбарын тоо | 1 | 2 | 3 | 5 | | | | 100 | УЦУОШТ, СЗДТГ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |
| *14.9* | *АОББҮХ 5.5.2* | Хүүхдийн оролцооны байгууллагууд, Өсвөрийн парламент, эко клуб, Youccan хөтөлбөрийн хүүхдүүдтэй хамтран өсвөр үеийнхэнд агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах | Нөлөөллийн ажиллагааны тоо / жилд | 2 | 10 | 20 | 50 | | | | 100 | Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, БОГ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |
| *14.10* | *АЗДҮАХ 3.3.5.1* | Сум, багийн хог хаягдлыг байгальд ээлтэй байдлаар ангилан ялгах, зайлуулан устгаж байгаа сайн туршлагыг судлаж нэвтрүүлэх | Нэвтрүүлсэн сайн туршлага | 1 | 5 | 10 | 20 | | | | 100 | Сумын ИТХ, ЗДТГ, БОГ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *14.11* | *АЗДҮАХ 3.3.2.1* | "Хашаандаа сайхан амьдаръя" урамшуулалт хөтөлбөр, аяныг зохион байгуулах | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 1 | 5 | 10 | 15 | | | | 100 | Сумын ИТХ, ЗДТГ төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |
| *14.12* | *АЗДҮАХ 2.4.1.2* | Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй технологийн үзэсгэлэн, худалдаа, сургалт зөвлөгөөн зохион байгуулах, мэдээллийг | Үзэсгэлэн худалдааны тоо | 0 | 2 | 3 | 4 | | | | 100 | Аймаг, сумын ЗДТГ, ГХБХБГ, БОГ, ХХААГ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |
| *14.13* | *АЗДҮАХ 3.3.5.1* | Айл өрх, ААН-үүд эко АЦБ нэвтрүүлэх хөтөлбөрт хамрагдан нүхэн жорлонгийн тоог бууруулах, нэгдсэн ариутгах татуургын шугам сүлжээнд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх | Нүхэн жорлон буулгахад үзүүлсэн дэмжлэгийн тоо | 1 | 2 | 3 | 4 | | | | 100 | Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, ГХБХБГ, БОГ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |
| *14.14* | *АЗДҮАХ 3.3.2.1* | Мод, бут тарьсан, ногоон байгууламж байгуулж тоосжилтыг бууруулсан иргэн, аж ахуй нэгжид урамшуулал олгох | Дэмжлэг үзүүлсэн ААН, байгууллага, айл өрхийн тоо | 10 | 10 | 10 | 10 | | | | 100 | Аймаг, сумын ИТХ, ЗДТГ, БОГ, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүд |

***Товчилсон үгийн тайлбар:***

УТ-улсын төсөв, ОНТ-орон нутгийн (аймаг, сум) төсөв, ТХ-төсөл хөтөлбөр, ОТ-олон талт эх үүсвэр
АХ- Алсын хараа, МУХТЖҮЧ- Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
УАӨДЗҮТ- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө
АЗДҮАХ-Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
АОББҮХ- Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр
ОЭМҮХ- Орчны эрүүл мэндийн үндсэний хөтөлбөр
ҮТХНЗХАХТ- Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

1825010052 9076298